

4

**ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛЫН СУРГАЛТАНД
ФИЛОСОФИ МЭДЛЭГИЙН ТУХАЙ****Ц.Гомбосүрэн Б.Дагзмаа**

Түлхүүр үгс: Эдийн засгийн шинжлэх ухааны эпистемологи онцлог. Эдийн засгийн философийн эпистемологи онцлог. Эдийн засгийн философи мэдлэг үүссэн түүхэн хугацаа. Эдийн засгийн философийн сонгодог онолууд. Эдийн засгийн философийн ХХ зуун дахь шинэхэн онолууд. Манай эдийн засгийн онолын бүтээлүүд дэх зарим философи үндэслэл, томъёолол.

Оршил үг: Эдийн засгийн онолын гурван үндсэн хэв маяг байдаг нь эдийн засгийн шинжлэх ухаан (ЭЗШУ), эдийн засгийн философи (ЭЗФ), эдийн засгийн тухай шашны онол гурав юм. Эдгээрийн дотроос ЭЗФ-ийн янз бүрийн чиглэл нь эдийн засгийн асуудлаархи шинжлэх ухааны мэдлэгэнд төдийгүй цөөнгүй нөхцөлд бас шашны онолын үндэслэлүүдэд эерэг байр сууринаас хандаж, тэдгээрт аль нэг утга оруулсан (үнэлэмжийн) тайлбар хийж иржээ. Улмаар XIX зуунд ЭЗФ (philosophy of economics) аваас нийгмийн философийн нэг гол салбар болон бүрэлдэж ирсэн байна. Гэхдээ түүнд холбогдох чухал чухал санаа, үндэслэлийг түүхийн өмнөх эрин үеүүдэд ч философичид бий болгож ирсэн байна.

Манай эдийн засгийн сургалтын янз бүрийн төвшин, тэдгээрт зориулсан сурах бичиг, гарын авлаганууд шинжлэх ухааны мэдлэгийг онцолдог нь зүй ёсны юм. Гэхдээ тийм бүтээлүүд ЭЗШУ-ын сэдвүүдээсээ гадна ЭЗФ-ийн түүхэн ба орчин үеийн мэдлэгийг өөртөө багтаадаг нь бас гарцаагүй шинжтэй байдаг. Гагцхүү тийм философи мэдлэг нь шинжлэх ухааны бусад төрлийн онолын мэдлэгтэй хэрхэн холбогдсоныг болон бас тэдгээр өөр өөр хэв маягийн мэдлэг ямар ялгаа бүхийг зориуд чухалчлан өгүүлсэн нь төдий л байдаггүй билээ. Ер нь сурах бичгэнд, хичээл заалтанд тийм зорилго тавиад байх шаардлага тэр бүр гардаггүй бололтой. Харин мэргэжлийн төвшинд бол судлаач хүн, багш хүн аваас ЭЗФ-ийн аль нэг чиглэл, ЭЗШУ хоёрыг тодорхой нэгдэлтэйгээс гадна ялгаатай байдлыг нь заавал харгалздаг байх ёстой. Энэ бол философи

ба ЭЗШУ аль аль салбарын мэргэжлийн хүмүүст хүчинтэй шаардлага мөн гэж бодож байна. Ийм бодолдоо дараах зарим үндэслэгээ гаргая. 1-рт, манай философичдын дотор “философи бол шинжлэх ухаан мөн” гэдэг Гегель, марксистууд зэрэг онолчдын үзлийг баримтлагчид эдүгээ ч гэсэн буй. Гэтэл аль XIX зууны дунд үеэс хойш философийн янз бүрийн чиглэл, сургууль бүхэн бол шинжлэх ухаан, урлагийн онол, шашин зэрэг мэдлэгийн төрлүүдийн аль нэгнийх нь юмуу зарим хэдийнх нь, эсвэл бүгдийнх нь тодорхой үр дүнд ямар нэг утга оруулсан жич жич үнэлэмжийн онол мөн гэдэг үзэл философийн амьдралд ноёрхох байр суурьтай болсон билээ. 2-рт, нөгөөтэйгүүр манай эдийн засгийн мэргэжлийн хүмүүсийн зарим нь ЭЗШУ-ын тайлбар, үндэслэл, тодорхойлолт хэмээн бичсэн зүйл нь шинжлэх ухааны биш, харин философи агуулгатай байдаг нь анзаарагддаг юм. 3-рт, МУИС-ийн философийн тэнхмээс янз бүрийн мэргэжлийн, түүний дотор эдийн засгийн салбарын магистрант нарт философийн тодорхой сэдвийг мэргэжлийнхээ шинжлэх ухааны мэдлэгтэй холбон бичих даалгавар өгөхөд тэдний зарим нь нэг бол зөвхөн шинжлэх ухааны асуудал авч үзсэн, эсвэл философи мэдлэгийг цулгуй хуулбарласан дутагдал гаргадаг юм. Харамсалтай нь МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн хойш хойшдын залуу багш ба судлаачдад ЭЗШУ, ЭЗФ хоёрын нэгдэл ба ялгааны асуудал бүр ч бүрхэг, аягүй бол ерөөсөө анзаарагдахгүй байх эрсдэлтэй болжээ. Тийм эрсдэлийн шалтгаан нь гэвэл тус салбар сургуулийн сургалтын төлөвлөгөө ёсоор философийг судлах нь оюутны хувьд сонголт (сайн дурын), магистрант ба докторант нарт бол аль алины нь сургалтын төлөвлөгөөнд огт падгүй тийм хичээл байгаа. Дунд сургуульд философийн хичээл байдаггүйг энд бас дурдъя.

Дээр дурдсан шалтгаануудыг харгалзвал ЭЗШУ, ЭЗФ хоёрын харьцааны асуудлыг онолын төвшинд дэвшүүлж, зөв шийдвэрлэн тайлбарладаг болоход эдийн засгийн онолын ба философийн аль аль салбарын багш, судлаачид мэргэжлийнхээ болон албан ажлынхаа ёс суртахууныг бодож, бас зохих боловсролтой, соёлтой хүмүүс мөнийхөө хувьд иргэнлэг сэтгэл гаргаж хамтын үйл ажиллагаа өрнүүлэх шаардлагатай хэмээн үзэж байна. Ийм өрнөлтөд холбогдох мэргэжлийн багш нар, судлаачдын анхаарлыг улам хандуулах зорилгоор энэ өгүүллийг бичив. Ингэхдээ эдийн засгийн философийн бүх сэдвийг толь бичиг шиг хамрах зорилго бид тавиагүй нь ойлгомжтой. Харин Монголын их дээд сургууль, коллежийн сургалтанд ашиглаж буй үндэсний болон гадаад хэлнээс орчуулсан сурах бичиг, гарын авлага дахь зарим ойлголт, томъёолол, үндэслэлийг онцолж, тэдгээрийн талаар философийн плюрализмын үүднээс өөрсдийн бодлоо илэрхийлэхийг бид зорьж буй болно. Ийм зорилтоо биелүүлэх гэсэн оролдлогондоо ашигласан онолын мэдээнүүдийн маань нэлээд хэсэг нь эдийн засгийн мэргэжил бүхий уншигч нарт улиг санагдах үндэстэйг ойлгож байна. Гэхдээ өмнө дурдсанчлан ганц эдийн засгийн биш, бас бусад мэргэжлийн хүмүүс, түүний дотор манай философичдын маань зарим нь философи, шинжлэх ухаан хоёрын төсөөг туйлчлаад ялгааг нь олж хардаггүйг илрүүлэхэд

тохиромжтойг харгалзаж тийм нийтэд мэдээж онолын зарим сургаалыг дурдахад хүрсэн болно.

*Нэг. Эдийн засгийн философи мэдлэгийн үүсэл
хэдийд, хаанахад холбогдох вэ?*

Эдийн засгийн амьдралын зүй тогтол, хөгжлийн жамыг тайлбарлах оролдлогыг грекийн философич Ксенофан анх гаргасан тухай эдийн засгийн онолчдын зарим нь бичсэн байдаг. Тэр бол “ойкономия (экономия-есопоту)” гэдэг нэр томъёог анх хэрэглэсэн философич аж. Уг нэр томъёо нь “өрхийг удирдах ухаан” гэсэн утгатай юм байна. Гэвч Ксенофаны “Ойкономи” гэдэг зохиолын агуулгыг зарим судлаач илэрхийлснээс бид дүгнэлт хийхэд грекийн энэ философич өрхийн аж ахуйг хөтлөх зохион байгууллалтыг философийн үүднээс биш, өөрөөр хэлбэл үнэлэмжийн онолын үүднээс биш, харин ерийн ухамсрын төвшин дэх танин мэдэхүйн бясалгал, дүгнэлтэнд үндэслэн авч үзсэн байна.

Ганц Ксенофаны ч биш, ер нь эртний Дорно дахины орнуудын болон эртний Грек, Ромын бусад сэтгэгчдийн зохиол, зарим хуулийн эмхтгэл зэрэг бүтээлд эдийн засгийн амьдралд холбогдох зөвлөмж, заалт, шийдвэр, бас номлол сургаал агуулагджээ. Тэдгээр дэх нэгтгэн ерөнхийлсөн шинжтэй мэдлэг нь ч гэсэн онолын мэдлэг биш (түүний дотор философи мэдлэг биш), харин ерийн ухамсрын төвшний сэтгэлгээний үр дүн юм.

Харин эдийн засгийн философи ойлголт боловсруулахад нэлээд ойлтсон сэтгэгч бол Аристотель аж. Тэрээр “баялаг” гэдэг ойлголт томъёолсныг энд онцлон дурдъя. Түүний томъёолсноор баялаг бол төр улсын (полисын) болон өрхийн амьжиргаанд гарцаагүй шаардагддаг эд юмс мөн. Тэрээр аж ахуйг эрхлэх ухаан (экономия), мөнгө хуримтлуулах, ер нь бүхэлдээ баяжих ухаан (хрематистик) хоёрын тухай ярьж, мөнгөн хуримтлал бол аж ахуйг эрхлэн хөтлөх, бас өөрийн хэрэгцээнээс давсан баян болох-ийм хоёр зориулалттай байдаг гэжээ.

Харин Дорно дахины болон бусад бүс нутгийн эдийн засгийн сэтгэлгээний тухай энд ул үндэстэй мэдээлэх чадал хүрэхгүй байгаагаа учирлан дурдъя.

*Хоёр. Эдийн засгийн түүхэн ба орчин үеийн онолууд дахь
философи агуулга*

Эдийн засгийн мэдлэг улмаар онол болж төлөвшсөн түүх нь шууд утгаараа XVII зуунаас эхтэй юм. Анхны тийм онолуудад шинжлэх ухааны танин мэдэхүйн зарим дүгнэлт, үндэслэл хуримталж эхэлсэн ч гэсэн бүхэлдээ бол түүнд философи мэдлэг ноёрхож байжээ. Тийм философи мэдлэгийн анхны түүхэн чиглэлүүд нь меркантилизм, физиократизм хоёр юм. Эдгээр нь улс оронд баялаг хуримтлах (арилжаа, газар тариалан гэх мэт) эдийн засгийн аль нэг уг сурвалжийг олж харахдаа түүнээ эдийн засгийн холбогдох нөхцөлд нь харгалзуулж үзэхгүйгээр харин бүх

нөхцөлд, бүх цаг хугацаанд хүчинтэй байх мэт ойлгосон аж. Улс орны амьдралын бүх нөхцөлд хүчинтэй ерөнхий онол бүтээсэн мэт туйлширсан агуулгатай, гэхдээ тодорхой нөхцөлд хүчинтэй байдгаараа зохих хэмжээгээр зөвшөөрөгдөх агуулга бүхий онолууд мөний хувьд меркантилизм, физиократизм хоёр бол эдийн засгийн философи сургаалууд юм.

Ийнхүү эдгээр сургаал аль аль нь тухайн үеийнхээ холбогдох практик үйл ажиллагааны мэдлэгт болон эдийн засгийн судлагааны үр дүнд тодорхой утга оруулсан, өөрөөр хэлбэл эерэгээр үнэлгээ өгсөн үнэлэмжийн онолууд мөн.

Гэвч XVII, XVIII зуунуудад тэр үеийн тэргүүний хөгжилтэй орнуудад эдийн засгийн амьдрал улам бүр олон талтай болон хөгжиж, судалгаа өргөжин гүнзгийрэхийн хирээр эдийн засаг бол аж үйлдвэр, хөдөө аж ахуй, арилжаа (түүний дотор гадаа худалдаа) зэргийн аль нэгний төдийгөөс биш, харин бүгдийнх нь цэцэглэлтээс хамааран хөгждөг нь (ялангуяа Английн эдийн засгийн амьдралын туршлагаас) улам бүр тодорхой болж иржээ. Ийм нөхцөлд улс орны нийт эдийн засгийн бодит хуулиудыг танин мэдэх зорилтыг сэтгэгчид өөрсөддөө хүчтэй тавих болсон байна. Тийм зорилтын тодорхой хэрэгжилтийн үр дүнд эдийн засгийн сонгодог сургаал үүсчээ. Уг сургаалыг үндэслэгч бөгөөд хамгийн том төлөөлөгч нь английн эдийн засагч, эдийн засгийн философич Адам Смит (1723-1790) мөн. Гол бүтээл нь 1776 онд анх хэвлүүлсэн “Үндэсний баялгийн мөн чанар, шалтгааны тухай судалгаа” гэдэг хоёр боть зохиол юм. Энэ зохиолд “эдийн засгийн хүн” гэдэг философи ойлголт байдаг. Үүнд, эдийн засгийн хүн бол бусад хүмүүст хэрэгцээт зүйл үйлдвэрлэж, түүнээ арилжаалах замаар ашиг олдог. Эдийн засгийн хүн бүрийн ийм ажиллагааны нийт үр дүнд нийгмийн баялаг бүтдэг. Аливаа эдийн засгийн хүн хувьдаа ашиг олохын тулд бусад хүнд юу хэрэгтэй байгааг мэдэж аваад түүний нь чанартай хийн, тэдэнд өгч, оронд нь өөрт хэрэгтэй юмыг тэднээс солилцоогоор олж авч байдаг. Ийм үйл ажиллагаа ширүүн өрсөлдөөнд явагддаг. Ийм өрсөлдөөн нь ашиг хожоо олохын төлөө аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй хүмүүсээс үл хамаармал зах зээлийн харилцаагаар зохьцуулагдаж байдаг гэж А.Смит үзжээ. Тэгээд тэрээр ийм харилцааг “далд гарын зохицуулалт” гэж нэрлэжээ. Улмаар тэрээр: эдийн засгийн хөгжлийг хангах орчин үеийн үндсэн механизм бол чөлөөт өрсөлдөөнд ба чөлөөт үнийн бүрэлдэлт мөн бөгөөд ийм механизмд төр саад хийх ёсгүй гэдэг философи үндэслэл дэвшүүлэн сурталчилсан байна.

Үүний зэрэгцээ зах зээлийн эдийн засагт төрөөс тодорхой нөлөө үзүүлдэг байхын чухлыг; тухайлбал монополийг хязгаарлаж, чөлөөт өрсөлдөөнийг дэмжсэн хууль батлан, эдийн засгийн амьдралд хэрэгжүүлэхийн чухлыг А.Смит шинжлэх ухааны мэдлэг, философи үзэл хоёрыг уялдуулсныхаа үүднээс үндэслэн тайлбарлажээ.

А.Смитийн дэвшүүлсэн эдийн засгийн философи үзэл бол нийгэм, улс төрийн либераль байр сууринаас бүтсэн онол юм. Америкийн орчин үеийн нэрт эдийн засагч Марк Скаузен бичихдээ: “Адам Смит дундаж хүний сайн сайхны төлөө ном бичсэн. Өөрийн оргил болсон бүтээлдээ тэрээр дэвшүүлж буй эдийн засгийн амжилтын загвараа “хамгийн доод ангийн хүмүүсийг оролцуулаад бүгдэд хүртээлтэй баялаг” бий болгох болно гэж уншигчдад амалсан байдаг...

Энэ нь хаад, язгууртанд зориулсан ном биш аж. Үнэн хэрэг дээрээ Адам Смит хувийн ашиг сонирхолтон, арилжааны эрх мэдэлтэй хүмүүст төдийлөн хүндэтгэлтэй ханддаггүй байсан юм. Харин хэдэн зууны туршид гадуурхагдан, элдэв хүчирхийлэлд автагдсаар ирсэн дундаж хүмүүст илүү талтай ханддаг байв”¹⁷ хэмээсэн. А.Смит ийм либераль эдийн засгийн философи байр сууринаасаа меркантилизмд эсрэгээр бичихдээ: баялаг бол эд юмс, алт эрдэнэ, аль нэг үндэстнийг шулж луйвраар хуримтлуулсан алт, мөнгө биш; харин үйлдвэрлэл ба солилцоо эрхэлж бүтээсэн зүйлс мөн. Улс орны баялаг нь зөвхөн алт мөнгө биш, харин тэр улсын газар нутаг, байшин барилга, янз бүрийн ашиглаж болох эд бараа мөн. Хүмүүс ямар сууцанд амьдарч, хувцаслаж, хооллож буйгаар баялаг хэмжигдэх ёстой. Хоол хүнс, амьдралын бусад шаардлагатай зүйлс хямд байж, амьдрал тав тухтай байх нь улс орны баялаг мөн гэсэн аж.

Францын эдийн засагч Жан Батист Сэй (1767-1832), Фредерик Бастиа (1801-1850) нар бол А.Смитийн сонгодог онолыг улам боловсронгуй болгох үндсэн дээр түүнийг эдийн засгийн судалгааны өргөн хэрэглэгддэг загвар болгосон хэмээн зарим судлаач үнэлсэн байдаг. Энд бид Ж.Б.Сэйгийн нэг чухал бүтээл болох “Улс төрийн эдийн засгийн ухааны шастир” гэдэг зохиол дахь философи үндэслэлүүдийг онцолж дурдах юм. Тэрээр үйлдвэрлэлийн хүчин зүйлс бол газар, хөдөлмөр, хөрөнгө (капитал) гурваас тогтдог хэмээгч сонгодог эдийн засгийн онолын үзлийг баяжуулж, “хувийн бизнес эрхлэгч бол үйлдвэрлэлийн бас нэг хүчин зүйл мөн” гэдэг томъёолол дэвшүүлж, тэр нь орчин үеийн олон сурах бичгэнд хүлээн зөвшөөрөгдөн сурталчлагдах болжээ. Шууд утгаараа “хувийн бизнес эрхлэгч” гэдэг нэр томъёо “хийгч, оролдогч” гэсэн үг. Давхар утгаар нь энэ үгийг “адал явдал хайгч” гэж орчуулсан. Энэ нь ашиг олох зорилгоор өөрийн хөрөнгө, мэдлэг, хөдөлмөрөө зарцуулан бизнес эхлүүлж, удирдан явуулдаг худалдааны адал явдал хайгч буюу азаа туршигч хөрөнгөтний дүр төрхийг илэрхийлнэ. Адам Смит багш хүн байсан бөгөөд бизнес огт эрхэлж байгаагүй. Хувиараа бизнес эрхлэх ямар ч туршлагагүй Смит “Үндэстний баялаг” зохиолдоо энэхүү амин чухал асуудлын ач холбогдлыг дутуу үнэлсэн байдаг. Харин Сей хөвөн даавуу үйлдвэрлэгч, хувийн бизнес эрхлэгч байсан. Иймээс ч энэ

¹⁷ Марк Скаузен. Эдийн засгийн ухаан. Эдүгээчлэгдсэн Замнал. Орч. Баабар, Л.Амарсанаа. УБ., 2003, 19 дэх тал.

асуудлыг өөрийн бүтээсэн эдийн засгийн загварын чухал хэсэг болгон авч үзсэн байдаг”¹⁸ хэмээн М.Скаузэн номондоо тайлбарсан байдаг.

Ж.Б.Сей бол ганц “хувийн бизнес эрхлэгч” гэдэг ойлголтоо биш, ер нь өөрийн боловсруулсан бусад чухал үндэслэлээ ч гэсэн эдийн засгийн бодит баримтанд тулгуурлан бий болгохыг чухалчилсан сэтгэгч юм. Тухайлбал тэрээр: үнэлэмжийн тогтмол жишиг бол хөдөлмөр мөн¹⁹ гэж английн сонгодог эдийн засгийн онолч Давид Рикардо (1772-1823) итгэл дүүрэн тайлбарласныг хийсвэрээр онолдсон алдаа хэмээн дүгнэсэн байдаг. Тэгээд Ж.Б.Сей: бараа, үйлчилгээний үнэ бол Д.Рикардогойн үзэж байгаачлан тэдгээрт шингэсэн хөдөлмөрийн өртгөөр биш, харин хэрэглэгчдийн таашаалаар тодорхойлогддог гэсэн ерөнхий (философи) үндэслэл дэвшүүлжээ. Бас эрдэмтэд “зах зээлийн хууль” гэж нэрлэдэг философи үндэслэлийг Ж.Б.Сей дэвшүүлсэн байна.

Кейнсийн онол гарч ирж, практикт хэрэгжиж ирсэн бараг 100 шахам жилийн турш Ж.Б.Сейгийн энэ үндэслэл үнэн зөв гэж үнэлэгдэж ирсэн байна. Тэрхүү үндэслэлийн агуулга нь: эрэлт, хэрэгцээ бол мөнгөнөөс хамаардаг бөгөөд мөнгөний хомсдол нь хэрэгцээг, улмаар арилжааг багасгадаг хэмээгч меркантилист онолд эсрэг байдаг. Үүнд, уг үндэслэлдээ Ж.Б.Сэй тайлбарласнаар мөнгө биш, харин бараа ба ажил үйлчилгээний үйлдвэрлэл л эрэлт, хэрэгцээг бий болгодог. Яагаад гэвэл мөнгө бол зөвхөн солилцооны хэрэгсэл болохоос эдийн засгийн зогсонги байдлын шалтгаан биш. Уг шалтгаан нь фермийн эзэд, аж үйлдвэр эрхлэгчид өөрсдийн бараа, ажил, үйлчилгээгээ арилжиж чадахгүй байгаад оршдог. Мөнгөний арвинаар биш, харин бусад бараа бүтээгдэхүүн элбэг болсноор арилжаа наймаа сайжирдаг. Энэ үйл явцад мөнгө зөвхөн дамжуулагч, зуучийн үүрэг гүйцэтгэдэг. Бүтээгдэхүүн элбэгшсэнээр хэрэглэгчдийн зарцуулалт нэмэгддэг чухам ийм угтаар үйлдвэрлэл аваас хэрэглээг тодорхойлж, бүтээгдэхүүний нийлүүлэлтээс түүний талаархи эрэлт хамаарч байдаг. Тиймээс хөрөнгө оруулалт бол эдийн засгийн хөгжлийн суурь болж байдаг.

Ж.Б.Сэйгийн болон түүнтэй үзэл нэгтнүүдийн ийм философи онол олонтой цохилтонд орж байсан боловч эдүгээ ч гэсэн нөлөө бүхий эдийн засагчид, эрдэмтдийн дотроос уг онолыг дэмжигчид гарсаар байдаг.

Адам Смитийн сонгодог онол болбоос францын сэтгэгчдийн үйл ажиллагааны үр дүнд тийнхүү оргилдоо хүрч байсантай зэрэгцээд уг онолыг доош татсан хоёр философи үзэл эх оронд нь гарч иржээ. Тэдгээрийн нэгийг нь Р.Т.Мальтус (1766-1834), нөгөөг нь Ж.-С. Милль (1806-1873) голлон төлөөлдөг.

¹⁸ Мөн тэнд, 64 дэх тал

¹⁹ Англи хэл дээрх “Labour Theory of value” гэдэг нэр томъёог манайхан “хөдөлмөрийн өртгийн онол” гэж орчуулж ирсэн нь оросоор “трудова я теория стоимости” гэж орчуулдгийг хуулбарласан бололтой. Гэтэл угтаа онолын төвшинд “value” гэдгийг “үнэлэмж” гэж орчуулбал зөв байдаг. М.Скаузений бүтээлийг англи хэлнээс орчуулагч нар дурдан буй нэр томъёог “хөдөлмөрийн үнэлэмжийн онол” гэж орчуулсныг бусад орчуулгаас дээр хэмээн бид энд сонгов.

Давид Рикардо, Жон Стюарт Милль нар бол Адам Смитийн үндэслэн боловсруулсан сонгодог эдийн засгийн онолыг зөвшөөрөн баримталжээ. Гэвч тэдний ийм байр суурь зөрчилтэй байв. Энд түүхэн дарааллын дагуу Д.Рикардог эхлээд дурдъя. Тэрээр А.Смитийн чөлөөт зах зээлийн эдийн засгийн онолыг зөвшөөрсөн боловч капиталист эдийн засгийн өсөлтийн тухай түүний (А.Смитийн) өөдрөг үзлийг үнэлэмжийн хөдөлмөрийн онол, амьжиргааны доод төвшингийн хөдөлмөрийн хөлсний хууль, ажилчин ангийн мөнхийн зовлонгийн тухай номлол зэргээрээ гутаан балласан тухай зарим судлаач дүгнэн дурдсан байдаг. Өөрөөр хэлбэл А.Смит ашиг сонирхлоор хөтлүүлдэг “жам ёсны зохьцолдоо”-г онолынхоо чухал баримжаа болгодог бол Д.Рикардо янз бүрийн анги, давхраа хоорондын зөрчилдөөнийг онцолсон аж.

Ж.С.Миллийн хувьд гэвэл тэрээр А.Смитийн либераль байр суурийг хамгаалсан нэг том төлөөлөгч нь ажээ. Тэрээр: өмчийг хамгаалах, мэргэжил эзэмших, хуримтлал бий болгох бололцоо олгодог зөвхөн тийм хөдөлмөр л өгөөжтэй бөгөөд мөнгө бол эдийн засагт тийм чухал зүйл биш байж, харин тэр нь зөвхөн цаг, хөдөлмөр хэмнэх төдий арга хэрэгсэл болдог; үнэ бол тухайн үед гүйлгээнд байгаа мөнгөний тоогоор зохицуулагддаг хэмээн сурталчилсан аж.

Үүний зэрэгцээ Ж.С.Милль хувийн өмч шударга, зохистой байхад үл итгэсэн нь Д.Рикардогийн нөлөө юм. Тэгээд тэрээр Р.Оуэн, Сен-Симон, Ш.Фурье нарын дэвшүүлсэн хамтын хоршооллын утопи социализм; эрх мэдлийг хүчээр авч, үйлдвэрийг улсын болгож, хувийн өмчийг устгах зорилго тавьдаг хувьсгалт социализм; үйлдвэрлэл ба үйлдвэрлэлийн хэрэгсэл, хуваарилалт ба солилцоог хянан зохицуулах хүнд суртлын систем бүхий фашист социализм гэсэн гурван төрлийн социализм байх бололцооны тухай ярьж, өөрөө хүчирхийлэлгүй (утопи) социализмд нь талтай байжээ. Гэвч амьдрал дээр хувьсгалт социализм нь ХХ зууны эхний олон арван жилд ялан оршиж, харин 80-аад онуудаас хойш олон оронд (түүний дотор социалист Монголд) ялагдал хүлээн, өөр нийгмээр солигдсон билээ.

А.Смитийн сонгодог онолыг эвдэхдээ энэ онолын нэг төлөөлөгч, гэхдээ А.Смитийн онолоос зөрсөн зарим үндэслэл гаргаж ирсэн Д.Рикардогийн философи баримтлалуудыг чухалчлан ашиглаж, улмаар бие даасан нэг хүчирхэг сургуулийг үндэслэсэн сэтгэгч бол Германы философич *Карл Маркс* (1818-1883) юм. Түүний эдийн засгийн онолд М.Скаузэн хувийн үнэлгээ өгөхдөө: К.Маркс бол аугаа боловсролтой, гайхамшигтай авьяаслаг, нийгмийн ухааны хамгийн аугаа том эрдэмтэн, сэтгэлгээний өвөрмөц сургууль бий болгосон анхны том эдийн засагч гэх мэтээр судлаачид үнэлсэн байдгийг дурдсаныхаа хамт түүний (Марксын) солилцоо нь эдийн засгийн ухааныг шинэ харанхуй үе рүү чирсэн хэмээн эрс мэдэгдсэн байдаг юм.

К.Маркс шинэ сургууль үндэслэгч мөнийхөө хувьд олон шинэ философи ойлголтыг эдийн засгийн онолд оруулсан ажээ. Тухайлбал

нийгмийн эдийн засгийн формац, материаллаг баялгийн үйлдвэрлэлийн арга, үйлдвэрлэх хүч ба үйлдвэрлэлийн харилцаа, нийгмийн эдийн засгийн суурь, нэмүү үнэлэмж (surplus value-манайд “нэмүү өртөг” хэмээн орчуулж, энэ дагуугаа гуйвуулсан ойлголт бий болгож ирсэн), “пролетарийн хоосрол” гэх мэт. Гэвч эдгээр ойлголт ба эдгээртэй уялдсан шинжлэх ухааны таамаглалууд алдаатай нь нотлогдсоныг судлаачид заадаг юм. Энд тийм шинжлэх ухааны алдааг нь авч үзэх явдал сэдвийн маань зорилгод чухал биш буй. Иймд түүнийг хөндөлгүйгээр харин зарим чухал философи дүгнэлтийг (өөрөөр хэлбэл үнэлэмжийн утгатай ерөнхий онолын дүгнэлтүүдийг) нь эдүгээгийн нийгмийн нөхцөлд ямар хувь заяа бүхий байгааг товч дурдъя. Үүний тулд К.Маркс эдийн засгийг төдийгүй нийгмийн нийт амьдралын янз бүрийн салбарыг шинжлэхдээ онолын ба арга зүйнхээ баримжаа болгосон үндэслэлүүдээ хэрхэн нэгтгэн илэрхийлснийг нь эхлээд ишлэх чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд, тэрээр “Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэх нь” зохиолынхоо Оршилд (1859 онд) бичихдээ: “... миний хүрсэн, хожим миний цаашдын бүх судалгаанд удирдлага болсон ерөнхий үр дүнг дор дурдсанаар товчхон томъёолж болно. Хүмүүс өөрсдийнхөө амьдралд нийгмийн үйлдвэрлэлд тэдний хүсэл зоригоос үл хамаарах, тодорхой зайлшгүй харилцаа, тэдний материаллаг үйлдвэрлэх хүчний хөгжлийн тодорхой шатанд тохирч байдаг үйлдвэрлэлийн харилцаанд ордог байна. Эдгээр үйлдвэрлэлийн харилцааны нийлбэр нийгмийн эдийн засгийн бүтэц, бодит суурийг бүрдүүлж дээр нь хууль цааз, улс төрийн давхарга сүндэрлэн, тэр сууринд нийгмийн ухамсрын тодорхой хэлбэрүүд тохирч байдаг байна. Материаллаг амьдралын үйлдвэрлэлийн арга нь амьдралын нийгэм, улс төр, оюун санааны процессуудыг ерөнхийд нь нөхцөлдүүлдэг. Хүмүүсийн ухамсар нь тэдний ахуйг тодорхойлдоггүй, харин ч хүмүүсийн нийгмийн ахуй нь тэдний ухамсрыг тодорхойлдог. Нийгмийн материаллаг үйлдвэрлэх хүч нь оршин буй үйлдвэрлэлийн харилцаа буюу түүний зөвхөн хууль цаазны илрэл болох өмчийн харилцааны дотор хөгжсөөр яваад хөгжлийнхөө тухайн шатанд тэрхүү харилцаатай зөрчилтэй болдог байна. Эдгээр харилцаа нь үйлдвэрлэх хүчийг хөгжүүлэх хэлбэр байснаа саад болон хувирна. Тэгэхэд нийгмийн хувьсгалын үе эхэлнэ. Эдийн засгийн үндэс өөрчлөгдөхийн хамт бүх асар том давхарганд удаан түргэн ч гэсэн эргэлт гарна.”²⁰ гэсэн юм.

Одоо энэ ишлэл дэх эдийн засгийн онолын ба нийгмийн онолын харилцан уялдаат үндэслэл тус бүрийн агуулгыг (өмнө зорилгоо хэлсэнчлэн) товч авч үзье.

1. “Материаллаг үйлдвэрлэлийн арга” гэдэг нэр томъёо аваас эдийн засгийн философид төдийгүй “материаллаг үйлдвэрлэл бол нийгмийн

²⁰ К.Маркс, Ф.Энгельс. Гурван боть түүвэр зохиол. 1-р боть, УБ., 1969, 561 дэх тал

амьдралын үндэс мөн” гэдэг марксист-ленинист нийгмийн философи үндэслэлд нэн чухал холбогддог.

Энд нэг зүйл тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд: марксист-ленинист философийн нэн чухал нэг бүрэлдэхүүн болж байдаг нийгмийн философи (social philosophy)–ийг энэ сургаалыг баримтлан хөгжүүлж ирсэн талынхан нь “түүхийн материализм” хэмээн (В.И.Лениныг даган) нэрлэдэг. Угтаа түүхийг материалистаар тайлбарладаг өч төчнөөн философи сургууль (XIX зуунд механицизм, арьсны өнгөөр ялгаварлах үзэл, Г.Спенсерийн органик сургууль, Мальтусын сургаал, XX зуун дахь аж үйлдвэржсэний ба аж үйлдвэржсэний дараах нийгмийн тухай олон хувилбарт онол гэх мэтээр) гарч ирж, зарим нь эдүгээ ч гэсэн нөлөөгөө хадгалж байдаг.

Угтаа материаллаг үйлдвэрлэлгүйгээр нийгэм оршин тогтнож чаддаггүй нь ойлгомжтой. Гэвч эндээс бидний дурдаад буй марксист-ленинист үндэслэлийг ямагт зөв байх юм шиг дүгнэлт хийвэл өрөөсгөл болдог. Тодруулан дурдвал нийгэм, улс орны амьдрал хэвийн оршин тогтнож, цааш урагшлан хөгжих үйл явцын үндсэн шалтгаан нь үлэмж олон нөхцөлд материаллаг үйлдвэрлэл байдаг ч гэсэн бусад нөхцөлд байгалийн юм уу нийгмийн шинжтэй, эсвэл аль аль нь уялдсан өөр өөр тодорхой хүчин зүйл байдаг. Тиймээс “нийгмийн амьдралын үндэс юу вэ?” гэдэг асуулт гарвал түүнд зөвхөн (“материаллаг үйлдвэрлэлийн арга” гэх мэт) нэг хүчин зүйлийг өрөөсгөлөөр онцолж биш, харин нөхцөл байдлаас хамаарч өөр ямар нэг тодорхой хүчин зүйл, зарим тохиолдолд хэд хэдэн хүчин зүйлийн уялдаа байж болох тухай олон ургальч зарчимд нийцсэн хариулт зөв практик гарцтай байдаг.

2. Нийгмийн үйлдвэрлэл бол үйлдвэрлэх хүч, үйлдвэрлэлийн харилцаа гэдэг хоёр үндсэн талтай байдаг тухай К.Маркс Оршилдоо тэмдэглэснийг марксистууд тууштай сурталчилж ирсэн бол зах зээлийн эдийн засгийн онол (ЗЗЭЗО)-д ийм үзлийг эергээр ерөөсөө дурддаггүйн шалтгааныг бид хойно философи байр сууринаас өгүүлэх болно.

3. Үйлдвэрлэлийн харилцаа бол нийгмийн бодит суурийг бүрдүүлдэг тухай К.Марксын дүгнэлт бол нийгмийн амьдралын үзэгдлүүдийн шалтгаан нь ямагт зөвхөн материаллаг үйлдвэрлэл байдаг гэсэн өрөөсгөл, монист үзлийн бас нэг илэрхийлэл мөн. Тодруулан дурдахад нэг хэсэг юм уу аль нэг орон дахь “нийгмийн бодит суурь” нь тэрхүү хэд хэдэн юм уу аль нэг орны тодорхой нөхцөлд материаллаг үйлдвэрлэлийн харилцаа байдаг ч өөр бусад нөхцөлд материаллаг үйлдвэрлэлийн биш харилцаа, түүний дотор байгаль, нийгэм хоёрын харилцаа байж болдог.

4. Капиталын хуримтлал тасралтгүй нэмэгдэж байдаг ч гэсэн капитализмын үед ашгийн хувь хэмжээ буурна гэж К.Маркс үзсэн нь худлаа болсон хэмээн орчин үеийн нөлөө бүхий зарим судлаач бүтээлдээ дурдсан байдаг.

5. Ажилчин анги улам бүр үгүйрсээр байх болно гэдэг онол нь бас биелсэнгүй. Энэ ангийн цалин хөлс сайн өсөж, амьжиргааны нь жишиг

мэдэгдэхүйц дээшилж иржээ. Өндөр хөгжилтэй орнуудын хүн амын дотор дунд ангийн эзлэх хувь нэмэгдсэн аж.

Энэ мэтээр К.Марксын гаргасан онолын алдааг судлаачид эдийн засгийн философийн үүднээс төдийгүй ер нь бүхэлдээ нийгмийн философийн үүднээс тоочдог юм.

Английн философич, социологич *Герберт Спенсер* (1820-1903) бол эдийн засгийн онолоор бичсэн ямар ч атугай сурах бичгүүдэд нэр нь төдий л гараад байдаггүй билээ. Гэвч түүний философи үзэл нь эдийн засгийн сургаалын олон сургуульд чухал нөлөө үзүүлсэн гэж зарим судлаач үнэлдэг юм. Үнэхээр ч Г.Спенсерийн чухам ямар философи үзэл нь эдийн засгийн сургаалуудад нөлөөлсөн бэ? гэсэн асуулт тавиад түүнд хариулт өгөх бололцоо байдаг. Үүнд: Г.Спенсер бол хувьслын үзлийн (эволюционист) баримтлал дэвшүүлж, уг баримтлалаа нийгмийн судалгаандаа, түүний дотор эдийн засгийн үзэлдээ арга зүйн утгаар дэлгэрүүлэн ойлгожээ. Тэрээр тийм философи баримтлал боловсруулсан нь нэн түрүүнд “Зүйлийн үүсэл” гэдэг Ч.Дарвины бүтээл дэх үзэл санааны нөлөө аж. Гэхдээ тэрээр Ч.Дарвины сургаал бий болохоос өмнө “хамгийн сайн зохицож чадсан нь амьд үлдэх” гэдэг томъёолол бий болгосон аж. Байгаль ёсны үйл явдал руу хөндлөнгөөс хөлөө дүрэх нь, тухайлбал социалист төлөвлөлт хэрэгжих нь биологийн доройтол руу хөтөлж, сайныг хохироогоод мууг дэмжихэд хүргэдэг гэж Г.Спенсер сурталчилжээ. Тэгээд эндээсээ нийгмийн үйл хэрэгт төр хөндлөнгөөс оролцдогийг, түүний дотор ядуусыг дэмжих, хүүхдийг хүмүүжүүлэх гэх мэтийн арга хэмжээг төр авдгийг хувьслын онолынхоо үүднээс шүүмжилдэг. Яагаад гэвэл төрийн тийм халамжлагч үйл ажиллагаа нь шалгарлыг зохиомлоор тасалж байна гэж Г.Спенсер үзжээ.

Тийнхүү Г.Спенсер эдийн засагт нийгмийн халамж байх нь сул дорой байхыг өөгшүүлдэг учраас хортой гэжээ.

Бүхэлд нь хэлбэл Г.Спенсер хувьслын онолынхоо үүднээс чөлөөт зах зээлийн эдийн засгийг зөвтгөсөн байна. Ийм байр сууринаасаа Р.Т.Мальтусын онолд үнэлгээ өгчээ. Хүн амын өсөлт аваас нөөц, баялагт дарамт учруулдаг хэмээгч Р.Т.Мальтусын үзлийг Г.Спенсер зөвшөөрөнгөө Р.Т.Мальтусаас ялгаатай онолын санаа илэрхийлсэн нь: “амьд үлдэн тэсдэг” байвал хөгжил, дэвшлийг урагшлуулдаг гэдэг үндэслэл мөн.

Г.Спенсерийн натурфилософи сургаалаас зарим үндэслэлийг нь бид ийнхүү онцлон дурдаж байгаа нь уг сургаалыг цулгүй зөвтгөх зорилготой биш, харин тэдгээр үндэслэл эдийн засгийн зарим онолд хэрхэн нөлөөлснийг илрүүлэх зориулалттай буй.

Кейнсийн онол. Английн эдийн засгч нар болох профессор Б.Сноудон, Х.Р.Вэйн нарын шинэхэн хамтын бүтээлээс энд эхлээд иш татъя.

“Дэлхийн II дайнаас хойш гарсан хамгийн нөлөө бүхий нэгэн өгүүллийнхээ эхэнд Фридман ... бичихдээ:

Эдийн засгийн бодлогын гол зорилго нь ажил эрхлэлт сайн, үнэ тогтвортой, өсөлт хурдтай байх явдал гэдэг дээр олон хүн санал нийлдэг. Эдгээр зорилгыг нэгэн зэрэг хангаж болно гэдэг дээр арай цөөн хүн санал нийлдэг. Өөрөөр хэлбэл эдгээр зорилго хоорондоо нийцэхгүй, иймээс нэг зорилгыг нөгөөгөөр нь орлуулах боломжтой, тэр нь ч дээр гэж үздэг хүмүүс олон бий. Харин бодлогын янз бүрийн арга хэрэгслээр хэд хэдэн зорилгод хүрч болно, хүрэх ч ёстой гэдэг дээр тун цөөн хүн санал нийлж байна...

Эдийн засгийн бодлогын гол зорилтуудад хүрэхийн тулд тохиромжтой арга хэрэгслийг хэрхэн сонгох нь макро эдийн засгийн тухайн онцлог асуудлын учир шалтгааныг хэр сайн задлан шинжлэхээс хамаарна. Макро эдийн засгийн сэтгэлгээнд сонгодог ба кейнсийн хандлага хэмээх хоёр гол уламжлалт чиглэл байдаг. Эдийн засагчдыг ингэж өөр өөр үзэл бодолтой байхад хүргэдэг үндсэн асуулт нь эдийн засаг дахь төрийн зохистой үүрэг оролцоо юу вэ? гэх асуулт юм”.²¹

Английн нэрт эдийн засагч *Жон Мэйнард Кейнс* (1883-1946) бол 1929-1935 онуудад капиталист ертөнцөд тохиосон Их Хямрал аваас А.Смит болон сонгодог онолын бусад төлөөлөгчдийн өөдрөг үзлийн нуралт хэмээн үнэлж, тэдний онолын бурууг засах тооцоотой хүчирхэг сургууль үндэслэн хөгжүүлсэн онолч мөн. Түүний хамгийн гол бүтээл нь 1936 онд бичсэн “Ажил эрхлэлт, мөнгөний хүү болон мөнгөний ерөнхий онол” гэдэг зохиол юм. Тэрээр энэ бүтээлдээ А.Смит болон ер нь нийт сонгодог онолчдын *Laissez faire* (эдийн засагт төр оролцохыг буруушаадаг зарчим)-г “алхайж суух” гэсэн утгатай болгож шүүмжлэн муучлаад: төр бол эдийн засгийг хямралаас гарган, хөгжил цэцэглэлтийн замд нь буцаан оруулах ганц хүч мөн гэж сурталчилжээ. Үүнд: төр бол макро эдийн засгийн төвшинд эрэлтийг нэмэгдүүлж, итгэл найдварыг хадгалах арга болох олон нийтийн ажилд зарцуулах мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх замаар ажлын байр, ханган нийлүүлэгчдийн тоог өсгөж, орлого ба хэрэглээг өсгөх үйл ажиллагаа явуулсны үр дүнд эдийн засаг сэргэнэ гэж онолын үүднээс тооцсон байна. Харин микро эдийн засгийн төвшинд *Laissez faire* бодлогыг баримталж болно гэж тэр үзсэн байна.

Кейнсийн онолын гавьяаны тухай зөндөө олон судлаач бичсэн байдаг. Тэдний дүгнэлтээр Их хямралын нөхцөлд тэргүүний хөгжилтэй орнуудад марксизмын нөлөө нэмэгдэх хандлага гарсныг таслан зогсоож, уг хямралыг капиталист тогтолцоонд төгсгөл учруулалгүй туулах арга зам байгаа гэсэн итгэлийг тэргүүний сэхээтнүүдэд Ж.М.Кейнс төрүүлсэн байна. Төсвийн дутуудлыг(алдагдлыг)бий болгох аргыг хэрэглэх замаар

²¹ Брайн Сноудон, Ховард Р.Вэйн. Орчин үеийн макроэкономикс. Үүсэл, хөгжил, өнөөгийн байдал. Орч. З.Манлайбаатар, Т.Оюунбаатар, Д.Гансүлд. УБ., 2010, 7 дахь тал

эдийн засгийг сэргээх загвар нь эдийн засгийг богино хугацаанд, зовлон шаналгаа багатай, сайн эмчлэх чухал хэрэгсэл болж өгсөн талтай аж.

Гэвч Ж.М.Кейнсийн онол нь эдийн засгийн өсөлтийг хангах төгс загвар болж чадаагүй төдийгүй сонгодог эдийн засгийн онолыг ул үндэсгүй цулгүй үгүйсгэдэг бөгөөд эдийн засгийн эрх чөлөөг боомилдог хэмээн нөлөө бүхий зарим онолч бас бичсэн байдаг. Тухайлбал төрийн хэт оролцоо, халамжлагч төр, данхгар төр, өсөн нэмэгдэх татвар зэргийг өөгшүүлэгч Ж.М.Кейнсийн үзэл нь тийнхүү марксизмаас хойш эдийн засгийн эрх чөлөөнд учирсан хамгийн ноцтой гамшиг мөн гэж тэд үздэг.

Хэдий тийм боловч кейнсизмийн тодорхой нөлөө эдүгээ ч гэсэн эдийн засгийн онол, практикт байсаар байна. Кейнсизм, түүний шинэ загварын тухай бүтээл арвин хэвлэгдэж ирсний дотор Поул А.Самүэлсоны “Эдийн засгийн ухаан (Economics)” гэдэг өч төчнөөн удаа газар сайгүй хэвлэгдсэн сурах бичиг хамгийн алдартай нь юм. Энэ ном бол кейнсч байр сууринаас эдийн засгийн философи, эдийн засгийн шинжлэх ухаан хоёрын уялдааг хангасан сурах бичиг мөн.

Кейнсизмийн эсрэг зарим онол дахь философи санаа. Энд эхлээд америкийн эдийн засагч М.Фридманы (1912-2006) боловсруулсан мөнгөний онол (монетаризм)-ын философи агуулгыг дурдья. Ж.М.Кейнсийн үед ужиг ажилгүйдэл эдийн засгийн хамгийн хурц асуудал байсан бол М.Фридманы үед инфляци хамгийн бэрхшээлтэй асуудал байв. Тиймээс М.Фридман мөнгөний онолын салбарт судалгаагаа төвлөрүүлсэн ажээ. Тэгээд: уналт, хямралд “мөнгө ямар ч падгүй”, мөнгөний нийлүүлэлтийг их хэмжээгээр нэмэгдүүлэх нь шууд үр дүн өгөхгүй гэдэг (тухайн үедээ хамгийн нөлөө бүхий байсан) кейнсч үзлийг шүүмжлэн няцаах ажиллагаа явуулжээ. Кейнсч онолын үүднээс бол чөлөөт хувийн бизнес дээр суурилсан капитализм тогтворгүй байдаг тул төрийн зүгээс “үр ашигтай эрэлт”-ийг нэмэгдүүлэн бий болгож байж, эдийн засгийн хэвийн оршин тогтнолыг хангана. Тиймээс А.Смитийн “далд гар”-ын хамт “ил гар” бас хэрэгтэй. Харин М.Фридман ийм үзлийг үл зөвшөөрөөд: мөнгөний тогтолцоо тогтворжоод ирэхийн цагт А.Смитийн жам ёсны эрх чөлөөний систем цэцэглэн хөгжих болно гэсэн дүгнэлт хийжээ. Өөрөөр хэлбэл мөнгөний тогтолцооны тогтворжилт гэдэг бол мөнгөний боловсронгуй стандарт, иймд мөнгөний алтан дүрэм баримтлагдаж, энэ нь эрх мэдэлтнүүд дур зоргын шийдвэр гаргахыг хязгаарлана гэж М.Фридман үзсэн байна.

Гэхдээ инфляцийн эсрэг монетаристуудын боловсруулсан мөнгөний стандартыг баримтлахад дэлхий дахин эдүгээ бэлэн биш байгааг мэргэжлийн хүмүүс сануулсаар байдаг юм. Мөнгөний боловсронгуйд үл итгэдэг байр суурь тэдэнд тод илэрч байдаг.

Австрийн либераль эдийн засагч *Фридрих А.Хаек* (1899-1992) бол социалист төвлөрсөн төлөвлөгөөг эсэргүүцэж, Laisser faire зарчмыг хамгаалахдаа энэ зарчмыг механикаар ойлгохоос зайлсхийсэн байр суурь илэрхийлж иржээ. Тэрээр бичихдээ: эдийн засаг, нийгмийн үйл

ажиллагааг урсгалаар сул орхиж болохгүй бөгөөд харин өрсөлдөөний боломжийг дээд зэргээр ашиглах чухал. Хэрэв өрсөлдөөн бий болгож чадвал энэ нь бодгалийн үйл ажиллагааг удирдах шилдэг арга болж өгдөг. Үр нөлөөтэй өрсөлдөөн бий болгоход сайтар бодож боловсруулсан хуулийн тогтолцоо хэрэгтэй. Үр нөлөөтэй өрсөлдөөний нөхцөл бүрдүүлэх боломжгүй газар эдийн засгийн үйл ажиллагааг удирдах өөр арга ашиглахаас аргагүй. Гэхдээ өрсөлдөөний нөхцөл байгаа газарт дээрээс зааварлаж уялдуулан зохицуулах үйлдлээр өрсөлдөөнийг хааж болохгүй. Ер нь хууль тогтоомжийг анх зохиоходоо өрсөлдөөнийг хөгжүүлэхээр зориуд тооцсон байх ёстой.

Ф.А.Хаек “эрх чөлөө” хэмээх философи ойлголтыг “төлөвлөлт”, “нийгмийн зорилго” зэрэг социалист үзэл баримтлалын агуулгыг шүүмжлэх зорилттойгоо холбон тайлбарласан юм. Түүний тайлбараар эрх чөлөө хангагдах баталгаат үндэс бол хувийн өмч мөн. Хувийн өмч бол өөр хоорондоо эрх мэдлийн хамааралгүй бодгаль хүмүүсийн мэдэлд байдаг болохоор тэднийг захирах онцгой эрх нэг ч хүнд байхгүй байж, тэд бие даасан шийдвэр гаргадаг байх ёстой. Энэ бол эрх чөлөө, ардчиллын бодит биелэл мөн. Гэтэл эрх чөлөөнд хамгийн их аюул учруулдаг юм бол тоталитар (дарангуйллын) дэглэмийн гол шинж болсон төлөвлөлт байдаг. Бүхнийг төлөвлөх, нэгтгэн зангидах, бүх нөөцийн ашиглалт, зарцуулалтыг төвлөрүүлж удирдах гэдэг бол тоталитар дэглэмийн өвчин мөн. Зохицуулах төв байгууллага байгуулахгүй бол нийгмийн амьдрал эх захаа алдна гэдэг сэтгэлгээ бол өрсөлдөөний зарчмын үйлдлийг огт ойлгоогүйн шинж мөн.

Улмаар ийм үзлийнхээ үүднээс тэрээр дүгнэхдээ: нийгмийн өмч ноёрхсон нөхцөлд хүмүүс бие даасан шийдэлд хүрэх эдийн засгийн тулгуургүй учир янз бүрийн мэдээлэл олж авах эрх чөлөөгүй; тийм шаардлага, хэрэгцээ ч үгүй байдаг. Ийм нөхцөлд мэдээлэл бүх чиглэлээр хаалттай байж, зөвхөн эрх баригчдын дохио зангаа бүхнийг чиглүүдэг. Тоталитар улс оронд либерал улс орны нэгэн адил “эрх чөлөө” гэдэг үг олонтаа хэрэглэгддэг боловч хамгийн их хэлмэгддэг. Яагаад гэвэл тэнд “хамтын эрх чөлөө”-ний тухай л яриа байдаг. Тэрхүү “хамтын эрх чөлөө” гэгч бол нийгмийн гишүүн бүрийн эрх чөлөө биш, харин нийгэмд дураараа дургих мэдэл бүхий нэгтгэн төлөвлөгчийн хүсэл эрмэлзэл байдаг. Угтаа нийгмийн зорилго бол нэгдмэл төлөвлөгөө биш, харин бодгаль хүмүүс зүтгэн ажилладгийнхаа үр дүнд өөрийнхөө болон нийтийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн үйл ажиллагаа байх ёстой гэж Ф.А.Хаек бас үзсэн байна.

Гурав. Манай эдийн засгийн сургалт, сурталчилгааны бүтээлүүдэд гардаг зарим философи ойлголт

Эдийн засгийн онолоор явуулж буй сурталчилгааны болон янз бүрийн шатны сургалтын бүтээлүүд агуулгын хувьд шинжлэх ухааны мэдлэгээс (хамгийн ерөнхийгөөр хэлбэл танин мэдэхүйн үр дүнгээс) гадна бас

үнэлэмжийн онолын мэдлэгээс, бүр тодорхой хэлбэл философи үндэслэлүүдээс тогтож байдгийг бид товч боловч авч үзлээ. Гэхдээ манайд тийм бүтээлүүд дэх философи утга бүхий үндэслэл, томъёолол, тайлбар зэргийг зарим зохиогч марксист-ленинист улс төрийн эдийн засгийн ухаанд нийцүүлж, харин өөр нэг хэсэг зохиогч зах зээлийн эдийн засгийн ухааны (ЗЗЭЗУ-ны) үүднээс тайлбарлаж байна. Үүнийг анзааран харгалздаг байх нь эдийн засгийн онолыг орчин үеийн соёлын төвшинд буюу мэргэжлийн төвшинд эзэмших шаардлагаас үүдэлтэй юм. Ийм тооцооны үүднээс эдийн засгийн философийн зарим чухал ойлголтыг манайд эдүгээ хэрхэн хэрэглэдгийг товч авч үзье.

1. *“Үйлдвэрлэлийн арга” гэдэг ойлголт.* Ялангуяа зарим философичдын бүтээлд энэ ойлголтыг эдүгээ ч эерэг утгаар хэрэглэсээр байна. Гэтэл зах зээлийн эдийн засгийн онол (ЗЗЭЗО)-д уг ойлголт хэрэглэгддэггүйн зарим шалтгааныг бид өмнө өгүүлсэн билээ. Тэдгээр шалтгааныг тодотгосон зарим зүйл нэмэн дурдья. Тухайлбал марксист онолчид үйлдвэрлэлийн арга хэв маягийн хувьд дэвшин дээшлэх замаар халагдан солигдож, эцсийн эцэст капиталист үйлдвэрлэлийн аргыг хувьсгалаар устган, социалист үйлдвэрлэлийн арга тогтоож, улмаар түүнээс коммунист үйлдвэрлэлийн аргад урган орох тухай утопи дүгнэлт хийсэн билээ. Коммунист дэглэм бүхий социалист орнуудад албадлагаар хэрэгжүүлж байгаад бүтэлгүйтсэн энэхүү философи үндэслэл аваас К.Маркс, Ф.Энгельс нар хувийн өмчийг мөлжлөгийн хэрэгсэл хэмээн үзэн ядаж, түүнийг бүр мөсөн устгах онолын ба нийгэм-эдийн практик зорилт тавьж ирсэнтэй салшгүй уялдаж ирсэн юм. Угтаа хувийн өмч мөлжлөгийн хэрэгсэл болдог эрсдэлтэй байдаг ч гэсэн нийгмийн (ялангуяа төрийн) өмч бас хувийн өмчөөс дутуугүй мөлжлөгийн хэрэгсэл болж байдаг нь; харин ч хувийн өмч бол нийгмийн өмчийг бодвол эзэнтэй, илүү арвигч байх үндэстэй, авилгад автах нь хязгаарлагдмал ба нэлээд тохиолдолд хаалттай, иргэн хүний эрх чөлөөг эдийн засгийн үүднээс баталгаатай болгодог гэх мэт давуу талтай нь либераль философийн үүднээс үндэслэгдэж, практик амьдралаар нотлогдож ирсэн билээ.

ЗЗЭЗО “үйлдвэрлэлийн арга” гэдэг марксист-ленинист философи баримтлалын оронд “үйлдвэрлэлийн хүчин зүйлс” гэдэг баримтлал боловсруулжээ. Угтаа энэ баримтлал бол шинжлэх ухааны чухал үндэстэй мэдлэг юм. Гэхдээ энэхүү шинжлэх ухааны баримтлалд философи санаа шингэсэн байдаг. Учир нь, сонгодог эдийн засгийн онол үйлдвэрлэлийн хүчин зүйлийг газар, капитал (хөрөнгө), хөдөлмөр гэсэн гурван бүрэлдэхүүнтэйн тухай заасан нь өнөөг хүртэл бараг хөндөгдөхгүй явж ирсэн байдал бол төгс үнэний илэрхийлэл гэгдэхээсээ үнэлэмжийн утгатай гэгдвэл эдүгээгийн онолын хүрсэн төвшин, нийгмийн бодит нөхцөл аль алинд илүү ойртохоор юм. Тодруулан дурдвал даяаршлын үйл явц, хүн төрөлхтөн оккультив ба эзотерик мэдлэгийг үйлдэлдээ ашиглах төвшинд ойртож буй зэрэг урьд өмнө төсөөлж байгаагүй үнэхээр гоц шинэ шинэ үзэгдэл үүсэж буй ба үүсэх хандлагатай байгаа нь

үйлдвэрлэлийн шинэ шинэ хүчин зүйлийн тухай ярих байдал руу хүргэх үндэстэй. Бас үйлдвэрлэлийн хүчин зүйл тус бүрийн онцлогийг илэрхийлдэг мэдлэг утгаа эдийн засгийн шинжлэх ухааны байх, иймд үнэнийг тогтоосон нэг янзын тайлбар байх шаардлагатай юм. Гэвч уг мэдлэг хэрэг дээрээ өөр өөр тайлбараар илэрсэн явдал бол тэдгээр тайлбарын зарим нь онолын төвшиний үнэлэмж буюу эдийн засгийн философи үр дүн мөнөөс шалтгаалдаг.

Бидний ийм дүгнэлийг зөвтгөх чухал үндэслэгээ эдүгээ ч нэгэнт бий болж эхэлсний нэг жишээ бол Ж.Б.Сейгийн (өмнө дурдсан) “хувийн бизнес эрхлэгч” гэдэг үйлдвэрлэлийн хүчин зүйлийн тухай үндэслэл мөн.

2. *Хөдөлмөр гэж юу вэ?* ЗЗЭЗО-ын бүтээлүүдэд хөдөлмөр бол эдийн засаг дахь “бараа үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг ажиллах хүчний нийлүүлэлт мөн”; “орлого олоход чиглэсэн үйлдвэрлэл ба үйлчилгээнд зориулж буй биеийн болон оюуны аль аль чармайлт мөн” гэх мэт томъёолол байдаг. Эдгээр томъёолол нь “эдийн засаг”, “орлого” гэх мэт ойлголт ЗЗЭЗО-ын утгатай байгаа нөхцөлд шинжлэх ухааны мэдлэг байх бүрэн үндэстэй. Гэтэл орчин үеийн зарим холбогдох бүтээл дэх хөдөлмөр бол “ажил хийж, хүч чармайлт гаргахыг хүмүүсээс шаардаж буй зорилготой, нийтийн таашаал хүлээдэг эрчимтэй үйл ажиллагаа мөн”²², “хүмүүсийн тодорхой зорилго бүхий бүтээлч үйл ажиллагаа мөн” гэх мэтээр илэрхийлж буй томъёоллууд бол зөвхөн шинжлэх ухааны утгатай шийдэл байх албагүй, бас үнэлэмжийн утга орсон байх үндэстэй тайлбарууд мөн. Үүнд, эл хоёр томъёолол аваас үйлдвэрлэлийн ба үйлдвэрлэлийн биш, арилжааны зориулалттай ба үгүй, орлого бүтээж, ашиг олоход чиглэсэн ба чиглээгүй, шударга ба шударга биш аль ч төрлийн үйл ажиллагаанд хүчинтэй байж чадахаар тийм ерөнхий утгатай юм.

3. *“Эдийн засаг” гэдэг категорин философи утга.* Монголын өнөөгийн зарим философийн зохиолд ч гэсэн эдийн засаг бол үйлдвэрлэлийн харилцааны цогц, нийгмийн суурь мөн гэдэг марксист томъёолол уламжлагдаж ирлээ. Энэ бол зөвхөн материаллаг үйлдвэрлэлийг “эдийн засаг” гэж үздэг, иймээс уламжлалт нийгмүүдийн эдийн засагт хамаатуулбал хүчинтэй (өөрөөр хэлбэл шинжлэх ухааны зохих үнэ цэнэтэй) байж болдог, харин ЗЗЭЗ-д үл тохирох тийм хязгаарлагдмал философи үндэслэлийг баримталдаг байдал юм. Харин ЗЗЭЗ-т хамаатуулдаг “эдийн засаг” гэдэг ойлголт бол ашиг олохын тулд аж ахуй эрхэлдэг үйл ажиллагааны үр дүн болсон аливаа баялгийн цогцыг, өөрөөр хэлбэл бараа(таваар) болж буй үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл бүхнийг хамран илэрхийлж байдаг.

4. *Эдийн засгийн хууль гэж байдаг уу?* Марксист-ленинист улс төрийн эдийн засаг ба диалектик материалист философиор онолын

²² Ийм утгатай томъёолол: Современный экономический словарь. УБ, 1999, номын 354дэх талд буй

боловсролтой болж төлөвшиж ирсэн үеийнхэнд хэвшмэл сэтгэлгээ маань хадгалагдсаар байгаагийн нэг гэрч нь эдийн засгийн амьдралд түгээмэл ба өвөрмөц объектив хууль, зүй тогтол ноёрхож байдаг тухай догматик үзэл мөн. Ийм үзлийн үүднээс эдийн засгийн хуулиуд бол “эдийн засгийн янз бүрийн үзэгдэл, үйл явц доторхи объектив шинж бүхий хамгийн гол, тогтвортой, байнга давтагдагч шалтгаан-үр дагаварт холбоонууд ба харилцан хамаарлууд мөн”²³. Гэвч марксист-ленинист илт үеэ өнгөрөөсөн үндэслэлүүдээс зайлсхийх гэсэн зарим зохиогчийн эрмэлзэл нь энэ иш татсан маягийн неомарксист тайлбаруудыг агуулгын хувьд тодорхойгүй логик зөрчилтэй, бас зохиомол холбоос бүхий санаануудтай болгож байна. Энэ иш татсанаасаа жишээ аван хэлэхэд диалектикт хууль бол мөн чанарыг нээдэг тухай онцлон өгүүлдэг бол эл ишлэлд хуулийг үзэгдлийн тухай мэдлэг гэсэн; эдийн засгийн хуулиуд бол (мөн чанарыг илрүүлэн нээсний үр дүн гэгддэг) объектив, тогтвортой, байнга давтагдагч холбоонууд мөн хэмээгч марксист--ленинист эдийн засгийн философи үзлийг зөвшөөрөн өгүүлдэг; тийн атлаа тийм холбоонуудыг бас янз бүрийн *үзэгдэл, илт үйл явдалд ч* ноёрхож чадах юм шиг санаа илэрхийлж, үүгээрээ үзэгдлүүдэд зүй тогтолт биш, харин тохиолдол шинж, тохиолдол холбоо ноёрхдогийг үл харгалзсан; шалтгаан-үр дагаварт холбоог марксист диалектик онцолдог бол энэ ишлэлд тийм холбооноос гадна харилцан хамаарлыг (философи арга зүйн хэлээр функциональ хамаарлыг) бас зэрэгцүүлэн өгүүлсэн, гэх мэт юм. Гэтэл аль эрт XIX зууны эхээр И.Кант байгалийн хуулиудын тухай мэдлэгийг хүртэл хүний субъектив бүтээл гэсэн санааг илэрхийлж байсан юм. Ийм үзлийн үүднээс хандвал эдийн засгийн амьдралын тухай онол, түүний дотор эдийн засгийн хуулиудын тухай мэдлэгт субъектив агуулгатай элемент байдаг.

Угтаа эдийн засгийн хуулиудын тухай ярих юм бол зөвхөн болзмолоор, дараах утгуудын хүрээнд байх бололцоотойг философийн болон эдийн засгийн онолын зарим нөлөө бүхий төлөөлөгч өгүүлсэн байдаг. Үүнд: 1-рт, эдийн засгийн хууль бол эдийн засгийн амьдралын янз бүрийн үзэгдэл ба үйл явцыг судлан илрүүлж тоочсон бөгөөд тэдгээрийн төсөө ба ялгааг, давтагдах ба давтагдах албагүй аль аль шинжийг тогтоосон мэдлэгийн тогтолцоо мөн (тийнхүү хууль бол мөн чанарын тухай мэдлэг байж чаддаггүй тухай позитивист үзэл энд арга зүйн хувьд илэрдэг); 2-рт, нийгмийн амьдралын бусад хүрээний адил эдийн засгийн амьдралд объектив хууль, зүй тогтол биш, харин тохиолдол зүйлс ноёрхдог (тиймээс капитализмыг пролетарийн хувьсгалаар устгаад социализмд шилжилтийн зорилтуудаар дамжин шилжиж, улмаар түүнээс социализмаас коммунизмд орох нь объектив зүй тогтолт, гарцаагүй

²³ См. Об этом напр.: Экономическая теория. Учебник для вузов. 3-е изд., М.-Харьков-Мн., 2000, с.16

шинжтэй гэдэг марксист-ленинист сургаалыг энэ үндэслэл арга зүйн хувьд няцаадаг) гэх мэт юм.

Хууль гэж юу болох тухай Өрнөдийн орчин үеийн философийн дээр дурдсан маягийн нөлөө бүхий үзлийн үүднээс дүгнэлт хийвэл 33ЭЗ-ийн хуулийн тухай ярья гэвэл эрэлт, нийлүүлэлт хоёрын хамаарлын тухай 33ЭЗО-ын үндэслэлийг тэгж үнэлэх үндэстэй байна. Эл үндэслэлийг ч гэсэн хууль гэж үзэх нь 33ЭЗ зөвхөн хэвийн оршин тогтнож, хөгжиж буй үед хүчинтэй бөгөөд жишээ нь өнөөгийн Монгол дахь зах зээлийн харилцааг гажуудуулсан тийм хэвийн биш эдийн засагт эрэлт, нийлүүлэлтийн хууль үйлчилж чадахгүй байна.

Эдийн засгийн амьдралд, ер нь нийгмийн нийт амьдралд хууль, зүй тогтол ноёрхдоггүй ч гэсэн харин давталт бодитойгоор хэрэгждэг гэдэг философи үзлийг ялангуяа постструктурализмын төлөөлөгчид хүчтэй сурталчилж ирсэн юм. Тохирох нөхцөл бүрдсэн үед хэрэгждэг давталт аваас өргөн ба явцуу хүрээний, эерэг ба сөрөг янз бүрийн хэв маягийн байдаг.

“Хууль, зүй тогтол” гэдэг диалектик философи үзэл, “давталт” гэдэг орчин үеийн философи үзэл хоёрын нэг чухал арга зүйн ялгаа гэвэл эхнийх нь үзэгдлүүдийн мөн чанарыг шинжлэх ухааны ачаар нээн илрүүлж болно гэдэг, харин нөгөөх нь давталт бол мөн чанарын төвшинд байх албагүй бөгөөд үзэгдлийн төвшинд хэрэгжилт бүрэн бодитой байдаг хэмээгч арга зүйг тус тус иш үндэс болгодог.

5. *“Labour theory of value” гэдэг нэр томъёо философи утгатай нь.* Зөвлөлт Холбоот Улсад хэвлэж байсан философийн ном зохиолууд “value” гэдэг үгийг онолын нэр болохынх нь хувьд “ценность” гэж орчуулсан байдгийг монгол хэл рүү “үнэлэмж” гэж хөрвүүлсэн нь англи үгний нь утгатай овоо харгалзагдсан байдаг. Гэтэл ЗХУ-ын үеийн эдийн засгийн бүтээлүүдэд тэрхүү англи үгийг орос хэлэнд “стоимость” гэж орчуулж, түүний нь манайхан “өртөг” хэмээн орчуулж хэвшээд улмаар тэрхүү англи нэр томъёог “өртгийн хөдөлмөрийн онол” гэж орчуулан хэрэглэж ирсэн билээ.

“Value-ценность-үнэлэмж” гэдэг нэр томъёог “стоимость-өртөг” гэж орчуулан хэрэглэж ирсний жинхэнэ шалтгааныг тогтоох гэвэл нэлээд ажил удаж магадгүй байна. Гэхдээ энд нэг тайлбар хийе. Марксист-ленинист УТЭЗУ-ныг коммунист дэглэм бүхий социалист нийгмийн албан ёсны үзэл суртлын нэн чухал нэг бүрэлдэхүүн болгож байсан нөхцөлтэй холбон үзвэл тийм сондгой орчуулга нь өртгийн хэлбэрүүд, түүний дотор нэмүү өртөг, улмаар үнэ бүрэлдүүлдэг шийдвэрлэгч хүчин зүйл зэргийн тухай К.Марксын онолыг зөвтгөхөд үйлчилж ирсэн байна.

Философи арга зүйн үүднээс бас нэг зүйл дурдъя. 33ЭЗ-ийн нөхцөлд бараа, үйлчилгээний үнэ нь юугаар тодорхойлогддог вэ?, тухайлбал бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд зориулсан хөдөлмөрийн өртгөөр үү, эсвэл хэрэглэгч (худалдан авагч)-ийн үнэлэмжээс (таашаалаас) үү гэдэг бол онолоор (бүр тодорхой хэлбэл шинжлэх ухаанаар) биш, харин эдийн

засгийн тухайн тодорхой практикаар шийдэгдэж байдаг асуудал мөн. Тодруулан дурдахад тухайн бараа юм уу үйлчилгээ (ЗЗЭЗО-ын үүднээс энэ хоёр адилхан “бараа” гэж нэрлэгдэх боломжтой нь ойлгомжтой) өөрийгөө бүтээхэд зориулсан хөдөлмөрийн зардлаар дандаа л, эсвэл дандаа үнэлэмжээр ямар үнэ бүхий байх нь тогтддог биш, харин орон зай, цаг хугацаа, түүхэн бодит байдал зэрэг янз бүрийн нөхцөлд эдгээр дурдсан дурдаагүй өөр өөр шалтгаан ба аргаар тухайн нэг төрлийн барааны боловч үнэ нь ялгаатай тогтоогдож байдаг.

Тийнхүү философи мэдлэг, философи арга зүй бол эдийн засгийн асуудлыг өөрөө нэг мөр, тууштай шийдвэрлэдэггүй боловч шинжлэх ухаан тэгж шийдвэрлэх, тэр (шинжлэх ухаан) нь өөрийгөө хөгжүүлэх, асуудлаа шийдвэрлэх, практиктай холбогдох зэрэгт нь танин мэдэхүйн ба үнэлэмжийн чухал нөлөө үзүүлдэг. Гэхдээ тийм нөлөөг философийн зарим чиглэл эерэгээр, зарим нь сөргөөр үзүүлдэг. Энэ нь судлаач хүн философийн янз бүрийн чиглэлийн мэдлэгт хянуур, шүүмжлэлтэй ханддаг байхыг шаардаж байдаг.

Ном зүй.

1. Адам Смит. Исследования о природе и причинах богатства народов. М., 1995
2. К.Маркс. Улс төрийн эдийн засгийн ухааныг шүүмжлэх нь. Оршил.- К.Маркс, Ф.Энгельс. Гурван боть түүвэр зохиол. 1-р боть, УБ., 1969
3. Альфред Маршалл. Эдийн засгийн ухааны зарчмууд. Орч. Чимэдийн Энхээ. УБ., 1997
4. Марк Скаузен. Эдийн засгийн ухаан. Эдүгээчлэгдсэн Замнал. Орч Баабар, Л.Амарсанаа УБ. 2003,
5. Брайн Сноудон, Ховард Р.Вэйн. Орчин үеийн макроэкономикс. Үүсэл, хөгжил, өнөөгийн байдал. Орч. З.Манлайбаатар, Т.Оюунбаатар, Д.Гансүх УБ., 2010
6. Ч.Баянжаргал. Зах зээлийн эдийн засаг: онолын үндсүүд. Сурах бичиг.УБ., 2010
7. http://www.intelros.org/books/opera_selecta/opera_selecta_26.pdf
http://www.hrono.ru/metodika/economy/economy_metod.php
<http://www.personal.umd.umich.edu/~delittle/Encyclopedia%20entries/philosophy%20of%20economics.pdf>
<http://www.eur.nl/english/master/philosophy-economics/>